



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/356

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны өрөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу Дашдаваагийн Дашдондогийн (СЮ63110417) эзэмшлийн Хэрлэн сумын 2 дугаар баг Баатрууд гудамжинд байршилтай үйлчилгээний зориулалттай 1599 м² газрыг "Старкатегинг" ХХК (5504007)-д 44 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. "Старкатегинг" ХХК-ийн эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Старкатегинг" ХХК-ийн захирал Ш.Гаалиймаад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны A/206 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

